



**АРХАНГАЙ АЙМГИЙН
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО
2011-2021 он**

Цэцэрлэг хот



АРХАНГАЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2011 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 05

Цэцэрлэг

“Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого
/2011-2021/-ыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “а” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого /2011-2021/-д аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн гаргасан саналуудыг тусгаж хавсралт ёсоор баталсугай.

2. Аймгийн Засаг дарга /Ё.Баатарбилэг/-д ДААЛГАХ нь:

а/Аймгийн хөгжлийн цогц бодлогын эхний үе шат /2010-2015/-д зохион байгуулж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон ИТХ-ын Төлөөлөгчдөөс гаргасан саналыг нэмж тусган 2011 оны II дугаар улиралд багтаан боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулах;

б/Аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, аймгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

в/Аймгийн хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэлүүдээр төсөл боловсруулан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад мэдээлж, хөтөлбөр, төслүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах;

г/Аймгийн хөгжлийн цогц бодлогын эхний үе шатны арга хэмжээний хэрэгжилтийн явцыг аймгийн ИТХ-ын хуралдаанд жил бүрийн 12 дугаар сард багтаан тайлагнаж байх;

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын 2006.06.22-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.МӨНХБАТ

ОРШИЛ

1. УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021)”-д тулгуурлан “Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого (2011-2021)”-ыг боловсруулсан бөгөөд энэхүү цогц бодлогод “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, “Монгол Улсын Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2015 он хүртэл)”, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль” болон Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүд, бүсийн болон хөрш зэргэлдээ аймгуудын хөгжлийн бодлогын үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар тусгалаа олсон болно.

2. “Архангай аймгийн хөгжлийн цогц бодлого (2011-2021)”-д “Архангай аймгийн хөгжлийн хөтөлбөр” (2008), “Архангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлт”, хэрэгжилт, үр дүн (2001-2004), (2004-2008), “Аймгийн хөгжлийн стратеги”, “Архангай аймгийн дэд хөтөлбөрүүд”, “Архангай форум-2010”, “Архангай-эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал” (2010), Архангай аймаг “Хүүхэд-2010” дэд хөтөлбөр, “Аймгийн эдийн засгийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай” (2010), “Архангай аймгийн орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд баримталж болох саналууд”, “Архангай аймгийн татварын хэлтсийн тайлан”, “Архангай аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” (2009-2011), “Архангай аймгийн хөдөлмөр, нийгмийн хамгаалал-эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал” (2010), “Архангай аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” (2010-2013) болон “Архангай аймгийн Хөдөө аж ахуйн салбарыг 2016 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”, “Архангай аймгийн тээвэр, авто замын газрын 2010-2015 оны хэтийн төлөвлөгөө”, “Архангай аймгийн “Нисэх хороолол”-ын ерөнхий төлөвлөгөө”, “Архангай аймгийн аялал жуулчлалын талаар баримтлаж буй бодлого” (2010-2020) , “Архангай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө” (2010-2020), 2008-2012 онд Архангай аймгийн ИТХ-ын баримтлан ажиллах үйл ажиллагааны чиглэл, Архангай аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг аймгийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүд, стратеги, хөтөлбөрүүд болон тус аймгийн Их тамир, Чулуут, Тариат, Батцэнгэл, Цэнхэр, Эрдэнэбулган зэрэг сумдын хөгжлийн стратеги, мастер болон хэтийн төлөвлөгөөнүүдэд тусгагдсан зорилтуудыг уялдуулан тусгасан болно.

3. Архангай аймгийн урт хугацааны хөгжлийн стратегийн зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг 2011-2015 он, 2016-2021 он гэсэн хоёр үндсэн үе шатаар авч үзсэн бөгөөд цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн болон түүний хэрэгжилтийг хангах механизмыг тодорхойлон цогц бодлогод тусгасан бөгөөд Архангай аймгийн цогц бодлогыг боловсруулахад “Монгол Улсын статистикийн эмхтгэл” (2009), “Архангай аймгийн статистикийн эмхтгэл” (2009), “Архангай аймгийн статистикийн хэлтсээс гаргасан статистикийн Бюллетень”(2006-2008)-ийг ашиглав.

4. Цогц бодлогыг боловсруулахад юуны өмнө Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого, Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах шаардлагыг харгалзан аймгийн хөгжилтэй холбогдсон статистик үзүүлэлтүүдэд Ходрик Прескоттын шинжүүрээр хийсэн прогноз шинжилгээ, улс, бүс, бусад аймгуудын хөгжлийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан болон аймгийнхаа хөгжлийн давуу болон сул талуудад хийсэн судалгаанд үндэслэн нийгэм, эдийн засаг, байгаль орчны стратегийн онцлог зорилтуудыг дэвшүүлэн тэдгээрийг хэрэгжүүлэх арга, механизмуудыг тодорхойлсон болно. Жишээлбэл, Архангай аймаг хүн амын төрөлтөөр улсын дунджаас харьцангуй бага, харин нас баралтаар өндөр байгааг харгалзан хөтөлбөрийн хэрэгжилтийн I үе шатанд улсын дунджид хүрэх, ДНБ-д эзлэх аж үйлдвэр, барилга байгуулалтын хувийн жин хэт доогуур байгаа учраас аж үйлдвэржүүлэх бодлогыг чухалд авч үзсэн, адуу, үхэр, хонины тоогоор улсдаа тэргүүлж байгаа давуу талаа ашиглан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх, нэг эмчид ногдох хүний тоо болон нялхсын эндэгдлээр улс, бүсүүдийн дунджаас ихээхэн дээгүүр байгааг харгалзан нэг эмчид ногдох хүний тоог Хангайн бүсийн дунджид, нялхсын эндэгдлийг улсын дундаж түвшинд хүргэх, улмаар харьцангуй сайн байгаа хүн амын жилийн дундаж өсөлт болон хүний хөгжлийн индексийг хөтөлбөрийн I үе шатанд улсын дундаж түвшинд, II үе шатанд аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн болно.

5. Архангай аймгийн хөгжлийн дүр зураг нийгмийн хүрээнд 2015 он гэхэд 1000 хүн амд ногдох төрөлт, нас баралт, нялхсын эндэгдэл болон хүн амын дундаж наслалт улсын дундаж түвшинд хүрч, ядуурал, ажилгүйдэл буурсан, 2021 он гэхэд хүн амын жилийн дундаж өсөлт болон хүний хөгжлийн индекс улсын дундаж түвшинд, боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинж олон улсын нийтлэг жишигт хүрсэн байна. Эдийн засгийн хүрээнд 2015 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1119.4 мянган төгрөг буюу 932.8 ам.доллар болж, боловсруулах салбарын үйлдвэрлэл 24.3 хувиар өсөх бөгөөд 2021 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1568.9 мянган төгрөг буюу 1307.4 ам.долларт хүрч, байгаль орчны доройтол саарч, газар ашиглалтын оновчтой тогтолцоо бүрдсэн байна.

НЭГ. АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

1.1. Архангай аймгийн хөгжлийн өнөөгийн байдал

Архангай аймаг 1923 онд байгуулагдсан, Монгол Улсын төв хэсэгт уул, ой, тал хээр хосолсон 55.3 мянган м² нутаг дэвсгэртэй.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлтээр 1-р сард -26 хэм хүртэл хүйтэрч, 7-р сард +28 хэм дулаардаг бөгөөд жилдээ 232.3 мм хур тунадас унадаг.

Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 15.7 хувийг ой мод, 75 хувийг малын бэлчээр, 15 хувийг тариалангийн талбай эзэлдэг.

Тус аймаг байгалийн үзэсгэлэнт газрууд олонтойгоос гадна балар эртний хүний гал голомтын үлдэгдэл, шинэ чулуун зэвсгийн дараах хүрлийн үеийн өвөрмөц дурсгал, буган хөшөө, Түрэг улсын их хаан Билэг, түүний дүү хун тайж Культегиний гэрэлт хөшөө, Хар Хорум хотын суурь зэрэг 582 онд босгосон гэрэлт хөшөөнөөс эхлээд XIII-XIX зууны үеийн бичигт болон хүн чулуун хөшөөнүүд, түүхийн эртний хийгээд дундад зууны үеийн олон дурсгалууд хадгалагдан үлдсэн байдаг.

Архангай аймаг 19 сум, 99 багтай, 26.5 мянган өрх, 91.0 мянган хүн амтай, нийт өрхийн 39,5 хувь нь аймаг, сумын төвд, 60.5 хувь нь хөдөө багт амьдардаг. Аймгийн хүн амын 66.6 хувийг 35 хүртэлх насны хүүхэд залуучууд, 50.7 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Нийт хүн амын 31.4 хувийг амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой хүн ам эзэлж байна.

Аймгийн хүний хөгжлийн индекс 0.723, хүн амын дундаж наслалтын индекс 0.710, хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс 0.924, нэг хүнд ногдох ДНБ-ний индекс 0.535 байна.

1000 хүнд ногдох төрөлт 23.3, нас баралт 6.7, цэвэр өсөлт 16.7. Хүн амын дундаж наслалт 67.6 байна.

Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 41674 мянга, ажиллагсад 39.3 мянга, бүртгэлтэй ажилгүйдчүүд 2312, ажилгүйдлийн түвшин 7.5 хувь байна.

2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 35 сургуульд 20 мянган сурагч суралцаж 964 багш ажиллаж байгаа бөгөөд нэг багшид 29.9 сурагч ногдож байна.

Суурь боловсролын хамран сургалт 93.8%, багшлах эрхтэй мэргэжлийн багшийн хангалт 100% байна.

2009-2010 оны хичээлийн жилд хүүхдийн 29 цэцэрлэгт 2931 хүүхэд хамрагдаж цэцэрлэгийн насны хүүхдийн 45.8 хувь нь хамрагдсан байна.

Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтанд 1756 буюу 29.2 хувь нь хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 75.0%-тай байна.

Эрүүл мэндийн салбар Нэгдсэн эмнэлэг, сумын 17, сум дундын 2, өрхийн 5 эмнэлэг, багийн бага эмчийн 76 салбар, 21 эмийн сан, 136 их эмч, 13 эм зүйч, 420 дунд мэргэжилтэн, 328 туслах ажилтны бүрэлдэхүүнтэйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхдагч болон хоёрдогч лавлагаат тусламж үйлчилгээг хүн амд үзүүлж байна. Мөн хувийн хэвшлийн 6 эмнэлэг тусламж үйлчилгээний чанарын хөтөлбөр хэрэгжүүлэн Эрүүл мэндийн даатгалын сангаас 80 орны

санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулж байна. Нэг их эмчид 669, нэг сувилагчид 357 хүн ногдож байгаа нь стандартын түвшнээс доогуур байна.

Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, эмнэлгүүдийн төсөв, материаллаг баазын хангамж, хүрэлцээ хангалтгүйгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Архангай аймаг 2009 онд тухайн оны үнээр 150067 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ үйлдвэрлэснээс ХАА-н салбарт 77.0 хувийг, аж үйлдвэр, барилгын салбарт 1.8 хувийг, үйлчилгээний салбарт 21.2 хувийг тус тус үйлдвэрлэжээ. Бусад аймагтай харьцуулахад эдийн засгийн салбарын бүтэц хоцрогдонгуй, мал аж ахуйд суурилсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зонхилж байна.

Орон нутгийн төсвийн орлого 2996,2 сая төгрөг, орон нутгийн төсвийн зарлага 5495,1 сая төгрөг, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 2218,5 сая төгрөг байна.

Улсын регистрийн санд бүртгэлтэй 678 аж ахуйн нэгж байгууллагаас 521 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Дэд бүтцийн хөгжил хангайн бүсийн бусад аймгуудыг бодвол харьцангуй сайн, Монгол Улсын авто замын хэвтээ тэнхлэгийн төв зам 7 сумын нутгаар дайран өнгөрдөг, Улаанбаатар-Цэцэрлэгийн чиглэлийн авто замын 90 гаруй хувь нь хатуу хучилттай, аймгийн бүх сум төвлөрсөн эрчим хүчний шугаманд холбогдсон.

Тус аймаг нь түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газар олонтой бөгөөд 2010 оны байдлаар 1208 ор бүхий 22 жуулчны бааз, 126 ортой 6 зочид буудал, 250 ортой “Хасу Шивэрт” амралтын газар ажиллаж байна. Монгол оронд ирж буй жуулчдын 10 орчим хувь нь Архангайд аялдаг гэсэн судалгаа байдаг.

Архангай аймгийн хөгжлийн үзүүлэлтүүдийг улс, бүс, бусад аймгуудынхтай харьцуулан үзэхэд:

1. Хүн амын харьцуулж болох гол үзүүлэлтээр, Тухайлбал: Хүн амын дундаж наслалт 67.6 буюу улсын дундаж түвшинд, 1000 хүн амд ноогдох төрөлт 23.3 нийт нас баралт 1000 хүн амд 5.29 буюу улс, аймгийн дундаж түвшингээс доогуур, нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 23.2 байгаа нь улс, бүсийн дунджаас дээгүүр, нийт халдварт өвчний гаралт 10.0 мянган хүн амд 643.6, түүний дотор цочмог халдварт өвчний тохиолдол 357.2 байгаа нь улс, аймгийн дундаж түвшингээс тус тус доогуур байна.

2. Улсын ДНБ-ний 2.4 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ нь 21 аймгийн дунджаас 0.12 хувиар илүү байна. ДНБ-ний бүтцийн хувьд мал аж ахуй хэт зонхилсон /77%/, аж үйлдвэр, барилга байгуулалт хэт доогуур /1.8%/, үйлчилгээний хувьд улсын дунджаас 25.5% бага, төсвийн татаастай аймаг гэж нэрлэгддэг.

3. Малын тоо толгойн хувьд адуу, хонь, үхрийн тоогоор улсад тэргүүлж байна.

4. Эрүүл мэндийн үзүүлэлтүүдээр, тухайлбал нэг эмчид ногдох хүний тоогоор улсын дунджаас 48.8%, 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлээр 18.3

хувиар тус тус их, харин бүртгэгдсэн халдварт өвчний тохиолдлоор улсын дундажаас 1.27 хувиар бага байна.

5. Боловсролын үзүүлэлтүүдээс хүний хөгжлийн индекс улсын дундажаас 2.5%, дунд боловсролд хамрагдалт 4 хувиар тус тус бага байна.

6. Жендерийн үзүүлэлтийн хувьд жендерийн хөгжлийн индексээр улсын дундаж түвшний хэмжээнд, харин жендерийн эрх мэдлийн индексээр улсын дундажаас 15.9 хувиар доогуур байна.

1.2. Архангай аймгийн хөгжлийн давуу болон сул талууд

Архангай аймгийг 2011-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурьдсан давуу болон сул талуудыг харгалзан үзэв. Үүнд:

Хөгжлийн давуу талууд:

- Аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл нь МАА, аялал жуулчлал, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл байх бүрэн боломжтой;

- Үхэр, хонь, адууны тоогоор улсдаа тэргүүлдэг давуу талаа ашиглан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах, тухайлбал, өндөр уулын үхэр сүрэг ихтэй сумдад цагаан идээний болон сарлагийн хөөвөр боловсруулах үйлдвэр, мөн бусад сумдад айраг, сүүг үйлдвэрлэлийн аргаар ариутган савлах, хуурай сүү үйлдвэрлэх, ноос угаах, эсгий хийх, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломжтой;

- Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн болон эмийн ургамал тариалахад тохиромжтой үржил шим бүхий газар нутагтай;

- Байгалийн дагалдах баялаг ихтэй учир байгалийн жимс, жимсгэнийг ашиглан экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон рашаан, цэвэр ус зэрэг савласан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой;

- Газрын хэвлийн ашигт малтмал, эрдэс түүхий эд болон байгалийн нөөцийг эргэлтэнд оруулах боломжтой;

- Аймгийн бүх сум төвийн эрчим хүчний системтэй холбогдсон учир жижиг дунд үйлдвэрлэлийг сумдад хөгжүүлэх боломж бүрдсэн;

- Монгол Улсын авто замын хэвтээ тэнхлэгийн төв зам тус аймгийн 7 сумын нутгаар дайран өнгөрдөг, Улаанбаатар-Цэцэрлэг-Солонготын даваа чиглэлийн авто замын 90 гаруй хувь нь хатуу хучилттай;

- Харилцаа холбоо, мэдээллийн дэд бүтэц харьцангуй давуу хөгжсөн, бүх сумын төв, зарим багийн малчид, иргэд хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамрагдсан;

- Байгалийн болон түүх, соёлын дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх өргөн боломжтой;

- Байгаль газар зүйн байршлын хувьд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл хөгжүүлэх, түүний дотор томоохон голууд дээр усан цахилгаан станц, усан сан барих, байгуулахад маш тохиромжтой байршилтай;

- Гадаргын болон гүний цэвэр усны нөөц сайтай;

- Мэргэжил, боловсрол, дадлага туршлагатай хүний нөөц сайн зэрэг болно.

Хөгжлийн сул талууд:

- Аймгийн эдийн засагт бэлчээрийн мал аж ахуйд суурилсан хөдөө аж ахуйн салбар голлох үүрэгтэй байгаа, эдийн засгийн салбарын бүтэц ихээхэн хоцрогдсон;
- Мах, сүүний үйлдвэрлэлийн түүхий эдийг тасралтгүй нийлүүлэх эрчимжсэн аж ахуй сул хөгжсөн;
- Газар тариалангийн салбарын аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэлийн техник, технологи хоцрогдсон;
- Эдийн засагт нөлөө үзүүлэхүйц томоохон үйлдвэр болон олзворлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжөөгүй;
- Байгалийн баялаг, эрдэс түүхий эдийн багагүй нөөцтэй боловч нарийвчилсан эрэл хайгуул хийгдэж нөөц нь бүрэн судлагдаагүй;
- Цахилгаан холбооны суурь сүлжээг иж бүрнээр нь тоон технологид шилжүүлэх, телевизийн олон сувгийг аймгийн нийт сум, багийн нутагт хүлээн авах боломж бүрдүүлэх, орчин үеийн мэдээллийн сүлжээнд сумдын төв бүрэн холбож чадаагүй;
- Зах зээлийн багтаамж бага, санхүү, төсвийн чадавхи сул;
- Дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдээгүй;
- Хүн амын өсөлт удаан, тархай бутархай байршилтай, ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр;
- Аж үйлдвэр, томоохон үйлчилгээний газар хөгжөөгүйн улмаас хөдөлмөрийн зах зээл хязгаарлагдмал
- Сумдын эмнэлгүүд орчин үеийн эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмжийн хангалт дутмаг;
- Эх, хүүхдийн эндэгдэл буурахгүй байгаа, эх барих эмэгтэйчүүд, нярайн эмчийн анхдагч сэхээн амьдруулалт, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хангалтгүй, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ бага, тусламж үйлчилгээний чанар хүртээмж хангалтгүй, эмч, эмнэлгийн мэргэжилтний хүрэлцээ, хангамж дутагдалтай
- Хүүхэд залуучууд чөлөөт цагаараа хөгжих, боловсрох орчин дутмаг;
- Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалан ан амьтан, ургамлын төрөл зүйл ховордох, бэлчээр талхлагдах, хөрсний элэгдэл, эвдрэл нэмэгдэх, цөлжилтийн үйл явц эрчимжих, нуур цөөрөм, гол горхи ширгэж усны нөөц хомсдох, ойн нөөц багасах, байгаль бохирдох зэрэг олон сөрөг нөлөөллүүд байна.

ХОЁР. АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

2.1. Архангай аймгийн хөгжлийн алсын хараа

Хүний хөгжилд тулгуурласан оновчтой бүтэц бүхий олон талт эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэн, хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлж, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын жишиг аймаг болно.

2.2. Архангай аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд:

1. Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.

2. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын жишиг аймаг болоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг бүх талаар дэмжиж, хөгжлийн таатай орчныг бүрдүүлснээр дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

3. Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлнэ.

4. Аймаг, сумын төв, багуудыг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.

5. Аялал жуулчлал болон хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарууд болгон хөгжүүлнэ.

6. Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бий болгон экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

ГУРАВ. ХҮНИЙ БОЛОН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Аймгийн хөгжлийн 1 дэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд тус аймагт ядуурал, ажилгүйдлийг тууштай бууруулж иргэн бүрийн амьдралын түвшинг тасралтгүй дээшлүүлнэ. Гэр бүлийг хөгжүүлж, хүн ам зүйн оновчтой бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд хүргэх боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг эрс сайжруулна.

3.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, дотоод гадаадын хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, 8000-аас доошгүй байнгын болон түр ажлын байрыг бий болгон, 1600-гаас доошгүй ядуу өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх замаар амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2 дахин бууруулж, ажилгүйдлийн түвшинг 5.5%-д хүргэнэ.

- Аймгийн хөгжлийн цогц бодлоготой уялдуулан “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах дунд хугацааны хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн чадвартай ажилгүй иргэн, ажил олгогч, албан бус хөдөлмөр эрхлэгчид, ажлын байрны захиалга, шинээр бий болж байгаа ажлын байрны тоо,

чанарыг илэрхийлсэн “мэдээллийн сан” бий болгож иргэдийг ажлын байраар хангах;

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 2 хүртэл хувиар бууруулах;

- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг арилгаж, мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага олгох сургалтанд жилд 400-аас доошгүй иргэдийг хамруулан мэргэжил эзэмшүүлж, ажил эрхлэх бололцоогоор хангах;

- Сумдад ахуй үйлчилгээний цэг, салбар нээн ажиллуулах, явуулын үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

- “Ажил олоход бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж насны бүтцээс шалтгаалсан ажилгүйдлийг бууруулах;

- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, зам, барилга, уул уурхай зэрэг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр зайлшгүй шаардлагатай мэргэжлийн ажилчин бэлтгэж, ажлын байраар хангах хувийн хэвшлийн мэргэжлийн сургалтыг дэмжих;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тэгш оролцоог ханган иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

- Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
- Дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэх бодлогын хүрээнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, хоршоо, фермерийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл хөгжүүлэх замаар дэмжлэг үзүүлэх;

- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн дотоод, гадаадын зээл тусламжийн хүрээг өргөтгөх;
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх;

3.2. Хүн ам зүй, нийгмийн хамгааллын бодлого

Хүн амын төрөлтийг дэмжих, нас баралтыг бууруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг бууруулах, хүн амыг өсгөх таатай орчин бүрдүүлэх замаар хүний хөгжлийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж нийгмийн халамжийг оновчтой болгон нийгмийн даатгалын үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжин, нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах замаар 1000 хүн амд

ноогдох төрөлт, нас баралт болон хүн амын дундаж наслалтыг улсын дундаж түвшинд хүргэж, орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагад бодлого, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

- “Хүүхэд” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төв, сумдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар иргэдийн орон нутагтаа тогтвор суурьшилтай амьдрах, ажиллах нөхцөлийг бүрдүүлж аймгийн хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, хүн амын тоог нэмэгдүүлэх
 - Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох нөлөөллийг сайжруулахад ажил олгогч, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллага, хэвлэл мэдээлэл, ТББ-уудын түншлэлийг өргөжүүлэх
 - Жендерийн суурь судалгаа хийж, жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
 - Гэр бүл, хүүхдийн хөгжлийн талаар цогц бодлого хэрэгжүүлэх

Стратегийн зорилт 2. Нийгмийн даатгалын сангийн тогтолцоог боловсронгуй болгоно.

- Нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай хүргэх, хамрагдалтыг өргөтгөх замаар сангийн орлогын зарлагад эзлэх хувийг 60 хувьд хүргэх
 - Иргэдийн нэрийн дансны мөнгийг баталгаажуулж, тэдний нийгмийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлж мэдээллийг ил тод болгох;
 - Малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, ажилгүйчүүдийг нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамруулах
 - Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нэр төрлийг олшруулах, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чиглүүлэх

Стратегийн зорилт 3. Гэр бүл, нийгмийн бүлгүүдийн аж байдлыг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог сайжруулах талаар үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах;
 - Гэр бүлийг хөгжүүлэх, гэр бүл, эмэгтэйчүүдэд чиглэсэн нийгмийн ажлын агуулга, арга зүйг өөрчлөх;
 - Аймгийн хүн амын хөгжлийн суурь судалгааг шинэчлэн, мэргэжлийн баг ажиллуулж, хүн амын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
 - Хүүхдийн “Тамир” зусланг Хангайн бүсийн загвар зуслан болгох;
 - “Нийгмийн цогц суурь үйлчилгээ” хөтөлбөрийн “Өрхийг чадавхижуулах” сургалтанд өрх гэр бүлийг хамруулах;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлт болон хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэнэ.

- Хүн амын өсөлтийн одоогийн түвшинг хадгалж, хүн амын боловсрол эзэмших, ажлын байртай болж амьжиргаагаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар төрөлтийг урамшуулах, түүнчлэн нас баралт, өвчлөлийг бууруулах арга хэмжээг эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, гэр бүл төлөвлөлтийг дэмжих асуудалтай уялдуулан хэрэгжүүлэх

- Хүн амын шилжих хөдөлгөөний урсгал, ялангуяа хот суурин руу шилжсэн хөдөлгөөнийг сааруулах зорилгоор нийгэм, эдийн засгийн өсөлтийг түргэсгэн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх

- Хүн ам, хөгжлийн холбогдолтой статистик мэдээллийг сайжруулж, нийгмийн бүлгүүдийн талаар тусгайлсан мэдээлэл, судалгааг өргөжүүлж үүнд үндэслэн орон нутгийн бодлого хөтөлбөрөө тодорхойлон хэрэгжүүлэх

Стратегийн зорилт 2. Нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай хүргэх, хамрагдалтыг өргөтгөх замаар хуримтлалын сангийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлнэ.

- Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих тэтгэврийн суурь тогтолцоонд аймгийн нийт хүн амыг хамруулах;

- Тэтгэврийн сангийн бие даасан байдлыг дэмжих замаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглах нөхцлийг бүрдүүлэх

Нийгмийн даатгалын мэдээллийг цахим картын хэлбэрт шилжүүлж үйлчилгээг шуурхай, ил тод болгох;

Стратегийн зорилт 3. Гэр бүл, нийгмийн бүлгүүдийн аж байдлыг сайжруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- "Хүүхдийн ордон" байгуулах;

- "Усан бассейн" байгуулах талаар судлан шийдвэрлэх;

3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого

Иргэдэд хүртээмжтэй, чанартай, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн боловсрол, соёлын үйлчилгээгээр тэгш хангах нөхцөл бүрдүүлж, соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалан хөгжүүлэхийн зэрэгцээ соёл урлагийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулна.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ.

- Сургалтын байгууллагын бүтэц хэв шинж, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгож, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэн үйлчилгээний чанарыг сайжруулах;

- Гүнзгийрүүлсэн сургалттай биеийн тамир, математик, байгалийн ухааны төрөлжсөн дунд сургууль, анги нээн хичээллүүлэхийг дэмжих
- Бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх;
- Архангай аймгийн “Багшийн коллеж”-ийн материаллаг баазыг түшиглэн “Архангай” их сургууль байгуулан багшийн мэргэжлийн зэрэгцээ инженер, эдийн засаг, хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх;
- Сум бүрт малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой хэлбэр болох явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэгийг бүх багт ажиллуулах.
- ЕБС-д электрон номын сан, алсын зайны сургалт нэвтрүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- Сургууль завсардсан хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох бүх хэлбэрийг дэмжих;
- Эмзэг бүлгийн хүүхдийн сурах боломжийг нэмэгдүүлэх;
- Бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсрол давхар эзэмшүүлэх арга хэмжээ авах;
- Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийг аймаг, сумдын төвд байгуулан ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургуультай хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүд байгуулж ажиллуулах;
- Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн бүхий л хүрээнд инновацийг нэвтрүүлэх;
- Сургууль, албан бус сургалтын чанарыг сайжруулах, эцэг эх, байгууллага, олон нийтэд түшиглэсэн боловсролын олон хувилбарт сургалтыг дэмжиж, “Багшийн хөгжлийн төв”-ийг байгуулна.

Стратегийн зорилт 2. Боловсролын бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлэн материаллаг баазыг бэхжүүлж, удирдлагын менежментийг сайжруулна.

- Цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах замаар хүүхдийн сурах, хүмүүжих орчин нөхцлийг сайжруулах, байр, танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх;
- Сургууль, цэцэрлэгүүдийг компьютержүүлж, интернетэд холбох, “Хүүхэд бүрт компьютер хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;
- Гадаад хэлний сургалтын чанарыг сайжруулж англи, орос, хятад хэлний сургалтыг нэмэгдүүлэх;
- Цэцэрлэг хотод иж бүрэн үйлчилгээтэй номын өргөө байгуулах;
- МСҮТ-ийн сургалтын агуулгыг шинэчилж, сургалтын чанарыг дээшлүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх;
- Боловсролын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэхэд дэмжлэг авах;
- Боловсролын салбарт ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж орон сууцны хөтөлбөрт хамруулах, хувиараа орон сууц барихыг дэмжин бага хүүтэй, урт хугацааны зээлд хамруулах;

Стратегийн зорилт 3. Соёл урлагийн салбарын үйл ажиллагааг зах зээлийн шаардлагад нийцүүлэн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

- Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Номын сан, музей, соёлын төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлэн хүн амд мэдээлэл, соёлын үйлчилгээг хүргэх төв болгон ажиллуулж мэдээллийн тоон сүлжээнд бүрэн хамруулан түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сэргээн засварлах ;
- Соёлын биет болоод биет бус өвийг хамгаалах, хадгалах, өвлөн эзэмших, түгээн дэлгэрүүлэх, ардын авъяастнууд, урчууд, уран бүтээлчдийг шинээр нээн илрүүлж тэдний бүтээлийг судлах сурталчлах, алдаршуулах ажлыг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлэх,

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

- Бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх Мянганы хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн сургалттай ахлах сургуулиуд байгуулах;
- Боловсролын тогтолцоонд хувийн хэвшлийн эзлэх байр суурь, хамрах хүрээг нэмэгдүүлэх;
- Сургууль завсардалт болон бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн арилгах;
- ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн бүтэц, хэв шинжийг олон улсын жишигт хүргэх;
- Мэдээлэл, харилцааны технологийг сургалтанд өргөн нэвтрүүлэх;
- Хөдөө аж ахуй, био болон нано технологи, мэдээллийн технологийн чиглэлээр авъяастай залуучуудыг сонгон шалгаруулж, өндөр хөгжилтэй орнуудад төрийн сургалтын сангийн зардлаар сургаж аймгийн ирээдүйн хүний нөөцийг бэлтгэх.

Стратегийн зорилт 2. Соёл урлагийн байгууллагуудын биеэ даан хөгжих оновчтой тогтолцоо бүрдүүлэн, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

- Соёл, урлагийн өвийг хадгалах хамгаалах, авъяастан, урчууд, уран бүтээлчдийг шинээр илрүүлж сурталчлах тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Аймаг, сумын соёлын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх;
- Орон нутгийн музейг эрдэм шинжилгээ-судалгааны арга зүйн төв болгох;
- Нийтийн номын санг цахим хэлбэрт шилжүүлэн салбар номын сан байгуулах;
- Сумдын номын санг интернэтэд холбож электрон каталогт шилжүүлэн мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах;

3.4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

Хүн амд эрүүл мэндийн ээлтэй, чанартай, цогц тусламж үйлчилгээг үзүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг найдвартай сахин хамгаална.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн эрүүл мэндийн салбарын бодлогыг тодорхойлж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах орчин үеийн тогтолцоог цогц байдлаар бүрдүүлнэ.

•Хүн амын эрүүл мэнд, өсөлт хөгжилд байгаль орчин, цаг уур, ундны ус, хүнсний бүтээгдэхүүний нөлөөллийн судалгаа явуулж, эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх;

- Аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

- Аймгийн эрүүл мэндийн салбарын бүтэц тогтолцоог боловсронгуй болгож, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах;

- Жирэмсний хүндрэлийг эрт илрүүлэх, зайн оношлогоо болон эмчилгээний сүүлийн үеийн арга технологийг аймаг, сумын түвшинд нэвтрүүлэх;

- Сум, сум дундын эмнэлгийн материаллаг бааз, оношилгоо эмчилгээний техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэн, мэргэшсэн боловсон хүчнээр хангаж, үйлчлүүлэгчдэд нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

- Эх, нялхсын өвчлөл, эндэгдлийг бууруулах аймгийн стратеги төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх

- Аймгийн нэгдсэн эмнэлэгт эсийн шинжилгээ хийдэг болох, мэргэжилтэн бэлтгэх

- Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай эмч, сувилагч бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадвар эзэмшүүлэх;

Стратегийн зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн хангамжийг сайжруулна.

- Эрүүл мэндийн байгууллагуудад түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлийг үе шаттай хийж, багийн эмч нарын мэдлэг мэргэжил, нийгмийн асуудалд анхаарч 100% унаажуулан, явуулын үзлэгийн байртай болгох

- Сумдын эмнэлгийг нэгдсэн сүлжээнд холбон, мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах;

- Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, засварлах, өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

Стратегийн зорилт 3. Нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт, уламжлалт, сэргээн засах эмчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

- Чийрэгжүүлэлт, сэргээн засах эмчилгээний төвүүдийг байгуулж, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж мэргэшүүлэх;

- Бүх сумдыг чийрэгжүүлэлтийн иж бүрэн тоног төхөөрөмж, орон тооны биеийн тамир-чийрэгжүүлэлтийн арга зүйчээр хангаж, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маяг болгон хэвшүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрүүл мэндийн салбарын удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн материаллаг баазыг бэхжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.

- Мэдээллийн болон интернет технологийн ололт амжилтыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх;
- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт цаасгүй эмнэлгийн технологийг туршиж, алсын зайн оношлогоог нэвтрүүлэх;
- Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд тулгуурласан үйлчлүүлэгчид хүрч үйлчлэх, тасралтгүй, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх;
- Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслэлээр хүн амыг жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах;
- Эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний чадварыг нэмэгдүүлж, эмчлэн анагаах чадамжийг улсын дундаж түвшинд хүргэх;
- Халуун рашаануудыг түшиглэн аялал жуулчлал, амралт сувилалын газар байгуулах
- Сумдад “Хүүхдийн эмчилгээ, хоол тэжээлийн сувилал” байгуулах;
- Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгийн байрыг засварлах, шинээр барих, өргөтгөх
- Аймгийн хэмжээнд “Хүүхэд, өсвөр үеийн төв” байгуулан тэдэнд зориулсан сургалтуудыг тогтмолжуулах;
- Сумдын эмнэлгийн материаллаг бааз, оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, мэдээгүйжүүлэлт, эх барих эмэгтэйчүүд, мэс засал, шүд, хүүхэд зэрэг зарим нарийн мэргэжлийн үйлчилгээг өргөтгөх;
- Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нийгмийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх;

Стратегийн зорилт 2. Өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар орчин үеийн дэвшилтэт арга ажиллагааг нэвтрүүлэн дундаж наслалтыг уртасгаж хүн амын эрүүл мэндийг сайжруулна.

- Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлгийн хөгжлийн төсөл боловсруулан хэрэгжүүлэх
- Орчин үеийн оношлогооны техник, технологийг нэвтрүүлэн параклиникийг цогцоор хөгжүүлж, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг бүсийн оношлогоо эмчилгээний стандартын түвшинд хүргэж, хангалт үйлчилгээг чанаржуулах;

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Архангай аймгийн хөгжлийн 2-4 дэх тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд 2011-2015 онд мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 2011-2015 онд 1.5 дахин нэмэгдүүлж, 1119.4 мянган төгрөг буюу 932.8 ам долларт хүргэнэ, 2016-2021 онд 1.4 дахин өсгөж, 1568.9 мянган төгрөгт буюу 1307.4 ам долларт хүргэж 2021 оныг 2009 онтой харьцуулбал 2.2 дахин нэмэгдүүлэн мэдлэгт суурилсан, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгоно.

4.1. Макро эдийн засгийн бодлого

Ойрын жилүүдэд малын гаралтай түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ашигт малтмал олборлох замаар аж үйлдвэр, барилгын салбарт өсөлт бий болгох боломжийг бүрдүүлнэ.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 5.8 хувьд хүргэж, салбарын бүтцэд бага зэргийн өөрчлөлт гарч аймгийн ДНБ-ий 76.7 хувийг ХАА-н салбарт, 1.4 хувийг аж үйлдвэрийн салбарт, 0.6 хувийг барилгын салбарт, 21.3 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ. 2015 онд 2005 оны үнээр тооцвол 97809.61 мянган төгрөгийн бараа, үйлчилгээ үйлдвэрлэх боломжтой болно.

- Сумдын хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулан **бичил бүсүүдийг эдийн засгийн чиглэлээр төрөлжүүлэх** төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр эдийн засгийн шинэ салбар, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоно;
- Аймаг, сумдын төвийн эдийн засгийн чадавхи, дэд бүтцийн багтаамжийг нэмэгдүүлж, хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой төвлөрөл үүсгэнэ;
- **“Архангай аймгийн хөгжлийн банк” байгуулна;**
- Аймаг, сумдын эдийн засгийн үйл ажиллагаанд аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо хоршин ажиллах, хамтарсан хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох тогтолцоо бүрдүүлнэ;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын эдийн засгийн зохицуулалтын эрх мэдлийг өргөтгөн иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ;
- Орон нутгийн өмч, татвар, санхүү, зээлийн эрх хэмжээг өргөтгөх замаар санхүү төсвийн эх үүсвэр бий болгоно.
- "Нэг сум-нэг шилдэг бүтээгдэхүүн" хөдөлгөөн өрнүүлж аймаг, сумдын өрсөлдөх чадвар бүхий брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгон улсын хэмжээнд болон гадаадын зах зээлд нийлүүлнэ;
- "Шилдэг бүтээл, оновчтой санал, шинэ техник-технологи, шилмэл бүтээгдэхүүн"-ийг үнэлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлж, үзэсгэлэн худалдаа, яармаг гарган нийтийн хүртээл болгоно;
- Тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэн урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх сан байгуулж, төсөв, санхүү, зээлийн бодлогоор дэмжинэ;
- Газар эзэмших, ашиглах, өмчлүүлэх ажлыг эрчимжүүлснээр газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулна;
- **Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, мал аж ахуйн түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах замаар экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина;**
- Үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдлэг, орчин үеийн өндөр технологи, менежмент, мэдээллийн технологийг тууштай нэвтрүүлнэ;
- Ашигт малтмалын ордуудыг түшиглэн уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж, уул уурхайн орчин үеийн техник, технологи нэвтрүүлнэ;
- Түүхий эдийн нөөцөд тулгуурлан барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулна;
- Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болгоно;

- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, дотоод, гадаадын зах зээлд гарах таатай орчин бүрдүүлнэ;
- Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьж, зээлийн хүүг үе шаттайгаар бууруулна;
- Бөөний худалдааны сүлжээг байгуулна;
- Аймгийн ДНБ-ий үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар 2021 онд тус аймгийг улсаас татаас авдаггүй өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг болгож, улмаар улсын төсөвт орлого төвлөрүүлдэг аймаг болгох зорилтыг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн ДНБ-ийг жилд дунджаар 4.9 хувиас доошгүй өсгөж, аймгийн ДНБ-ий 76.1 хувийг ХАА-н салбарт, 2.3 хувийг аж үйлдвэр салбарт, 0.5 хувийг барилгын салбарт, 21.1 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ. 2021 онд 2005 оны үнээр тооцвол 130314.37 мянган төгрөгийн бараа, үйлчилгээ үйлдвэрлэх боломжтой болж 2015 онтой харьцуулбал ДНБ-ий хэмжээ 1.3 дахин нэмэгдүүлнэ.

- ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ;
- Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулах замаар хөдөө аж ахуй-аж үйлдвэр хоршсон аж ахуйн нэгжүүдийг байгуулна;
- Орон нутгийн мах, сүү, цагаан идээ, арьс шир, хөөвөр, ноос, ноолуур зэрэг түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг байгуулна;
- Хөдөө аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлнэ;
- Уул уурхайн салбарт эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлнэ;
- Өндөр технологид тулгуурласан, байгаль орчинд халгүй, ЭКСПОРТЫН баримжаа бүхий алт, төмрийн хүдэр, зэс боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлнэ;
- Оёдол, ахуйн үйлчилгээний уламжлалт болон орчин үеийн үйлчилгээнүүдийг шинээр бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- Аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбар болгоно.

4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого

4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Аж үйлдвэрийн салбарын жилийн дундаж өсөлт нэгдүгээр үе шатанд 19.2, хоёрдугаар үе шатанд 13.7 хувь байх ба түүний ДНБ-д эзлэх хувийн жинг 2015 онд 2 дахин нэмэгдүүлж, 2021 онд 2.3 хувьд хүргэнэ.

4.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина.

- Геологийн том масштабын зураглал бий болгоно;
- 1:50000-ны масштабтай геологийн зураглалыг аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хийж дуусгана;
- Хэтийн төлөв сайтай ашигт малтмалын орд, илрэлүүдийг шинээр нээн илрүүлэх, тэдгээрт геологийн нарийвчилсан судалгаа хийх боломжийг бүрдүүлнэ;
- Эрдэс баялгийн ашиглалтыг нэмэгдүүлж эрдэс баялгийн чадавхийг сайжруулах таатай нөхцлийг бүрдүүлнэ;
- Эрдэс баялгийн нөөцийг бүрэн тогтоож, ашиглах, байгаль орчныг хамгаалах үүднээс гүний судалгаа хайгуул хийнэ;
- Ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулахад шаардлагатай дэд бүтэц бүрдүүлнэ;
- Уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх асуудлыг дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлэнэ;

Стратегийн зорилт 2. Эрдэс, түүхий эдийн нөөц, баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, уул уурхайн салбарыг хөгжүүлнэ.

- Төвшрүүлэх сумын Жаргалантын цагаан тугалганы ордод нарийвчилсан эрэл хайгуул хийнэ;
- Хотонт сумын Манхан Элс, Өндөр Улаан сумын Хойт Элстэйн барилгын элсний ордуудад эрэл-үнэлгээний судалгаа хийж, нөөцийг нь үнэлнэ;
- Тариат сумын Шаврын царам, Жаргалант сумын Гүртийн нурууны өнгөлгөөний чулууны ордыг судалж технологийн туршилт хийж, ашиглана;

Стратегийн зорилт 3. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах бодлого баримтлана.

- Уул, уурхайн ашиглалтад хамрагдсан талбайн нөхөн сэргээлтийг сайжруулна;
- Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандарт мөрдүүлнэ;
- Уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ашигт малтмалыг далд аргаар олборлох, газрын гүнд боловсруулалт хийхийг дэмжинэ;
- Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорхи усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг багасгана;
- Экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор гол мөрний эх, ай сав, ойн бүс, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

- Эрдэс, түүхий эдийн нөөцийг иж бүрэн ашиглах, хаягдалгүй, байгаль орчинд халгүй, өндөр технологи нэвтрүүлнэ;
- Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүн гаргалтыг нэмэгдүүлнэ;
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ;
- Уул уурхайн болон барилгын үйлдвэрлэлийн өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэнэ;
- Алтны шороон ордуудын хувьд дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишээгээр пролювийн болон гүний дарагдмал ордуудыг эрж хайхыг ойрын зорилт болгоно;
- Хашаат сумын Зүүн Булгийн шатдаг занарын ордод хайгуул хийж, ашиглалт явуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна;
- Хангай сумын Зоогийн төмрийн орд, Төвшрүүлэх сумын Тамирын голын төмрийн хүдрийн ордуудад хайгуул хийж, ашиглалт явуулах техник, технологийн үндэслэл боловсруулна.

4.2.1.2. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 24.3 хувиар өсгөнө.

- Байгаль орчинд зохицсон, эдийн засгийн бусад салбартай уялдсан, нөөц боломж, тэргүүний техник технологид тулгуурласан, хүн ам болон үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээг хангасан боловсруулах болон барилгын материалын үйлдвэр хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ;
- Үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, менежментийг сайжруулна;
- Экспортын баримжаатай хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангана;
- Эрдэс, түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглахад чиглэсэн үйлдвэрлэлийг өргөтгөнө;
- Аймгийн эдийн засгийн бүсийн хөгжлийн төвүүд хоорондын зохистой харьцаа, хоршилтыг тогтоож, тэдгээрийг холбон хөгжүүлэх дэд бүтцийн үндсэн сүлжээг бүрдүүлнэ.

Стратегийн зорилт 2. Өрсөлдөх чадвартай боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж, эдийн засгийн төрөлжилтийг сайжруулна.

- Сумдыг бүсчлэн хөгжүүлж, бичил бүсүүдийг эдийн засгийн талаар төрөлжүүлэн хөгжүүлнэ;
- **Хоргын бүсэд** алт, үнэт чулуу зэрэг ашигт малтмал, уул уурхайн болон барилгын материалын болон сарлагийн хөөвөр, хялгас, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал хөгжүүлнэ;
- **Хүнүйн голын бүсэд** арьс шир, бусад түүхий эд боловсруулах үйлдвэр, рашаан амралт зэрэг үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ;
- **Өгийг бүсэд** уул уурхайн болон хөнгөн хүнсний үйлдвэр, аялал жуулчлал, усалгаатай газар тариалан хөгжүүлнэ;
- **Булган уулын бүсэд** хөнгөн аж үйлдвэр, аялал жуулчлал, рашаан амралт зэрэг үйлчилгээний салбар болон газар тариалан түлхүү хөгжүүлнэ;
- Модны тарьц үржүүлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дэмжинэ;
- Сумдад оёдол, нэхмэл, сүлжмэл эдлэл, **тоосгоны үйлдвэр**, махны механикжсан зоорь, хүнсний ногоо даршлах, нөөшлөх, савлах цех, ногооны хүлэмжийн аж ахуй, хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах цех байгуулна;

- Цэцэрлэг сумын Мухар хужирт, Цагаан толгойн рашааны найрлагыг тогтоон савлах технологийг нэвтрүүлнэ;

Стратегийн зорилт 3. Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) эрхлэгчдэд үзүүлэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.

- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд лизингээр тоног төхөөрөмж олгох үйлчилгээ хөгжүүлнэ;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн сан, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ;
- Мах, ноос, ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх, боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулан бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулна;
- Ахуйн үйлчилгээний орчин үеийн төрөл бүрийн жижиг үйлдвэрүүд байгуулахыг бодлогоор дэмжинэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг жилд дунджаар 15.9 хувиар өсгөж, аймгийн аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 57.5 хувьд хүргэнэ.

- Өндөр технологи нутагшуулах төв байгуулан аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулах цемент, барилгын бетон хийц, тоосго, эрдэс будаг зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ;
- Сумдын бүсийн төвүүдэд үйлдвэрлэл, технологийн холимог, дагнасан хэлбэрийн парк байгуулна;
- Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ;
- Эрдэс, түүхий эд болон байгалийн бусад баялгийг иж бүрэн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрүүдийн байршил, бүтцийг оновчтой тогтоож хөгжүүлнэ.

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллана;
- Түүхий эдийн нөөц, хүн ам, зах зээлийн багтаамжид нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрүүдийн байршлыг тогтоон байгуулна.

4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого

- Өндөр ашиг шимтэй нутгийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчээр хангаж, бэлчээрийн даац, чадавхийг зөв ашиглах, малын тэжээл, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэн төрөлжсөн, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх замаар хөдөө аж ахуйн загвар аймаг болох;

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан ХАА-н салбарын үйлдвэрлэлийг жилд дунджаар 6.7 хувиар, мал аж ахуйг 6.8 хувиар, газар тариаланг 4.5 хувиар тус тус өсгөнө.

- Аймгийн мал аж ахуйг эрчимжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ;

- ХАА-н үйлдвэрлэлийн одоогийн бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн менежментийг нь боловсронгуй болгоно;
- Мах, сүүний эрчимжсэн аж ахуйг өргөжүүлж, сумын бүсийн төвүүдийг түшиглэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ;
- Мал сүргийн бүтцийг зохистой тэнцвэрт хэмжээнд байлгах болон үхэр сүргийн тогтвортой өсөлтийг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ;
- Сүргийн бүтцэд өндөр ашиг шимт үүлдрийн малын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ;
- Газар тариалан, мал аж ахуй хосолсон эрчимжсэн фермерийн загвар аж ахуйнуудыг байгуулна;
- Мал эмнэлэг, үржлийн алба, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлэн мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангана;
- Мал эмнэлгийн техник, технологи, эм хангамжийг сайжруулан, малын халдварт паразит өвчнөөс урьдчилан сэргийлнэ. **Зарим эм био бэлдмэлийг үйлдвэрлэх чадавхийг дээшлүүлнэ.**
- Мал эмнэлгийн үйлчилгээг зах зээлийн зарчимд нийцүүлэн мал эмчлэх, үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжинэ;
- Мал эмнэлгийн ариун цэвэр, магадлан шинжилгээний лабораторийн техник, тоног төхөөрөмжийн хангамж, оношлогооны чадавхийг дээшлүүлнэ;
- Ихтамир сум дахь өндөр уулын бүсийн МАА-н эрдэм шинжилгээний салбарыг өргөжүүлнэ;
- Сумдын түвшинд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог зохистой байдлаар шийдвэрлэж, шилмэл малын удмын сан бүрдүүлэх замаар нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлнэ;
- Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн багтаамж, даацыг нэмэгдүүлнэ;
- Таримал ургамал, үр бордоо, өндөр ашиг шимт болон нутгийн шилмэл омгийн хээлтүүлэгч мал, өсвөр гахай, өндөглөгчийн талаар иргэд, өрх, аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачлагыг дэмжинэ;
- ХАА-н үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалан, мал сүргийг индексжүүлсэн даатгалд хамруулна;
- Боллоцоотой сумдад зөгий, гахайн аж ахуй байгуулна;
- Нутгийн хурдан удмын адууны цөм сүрэг бий болгоно;
- Сэлэнгэ үүлдрийн үхэр сүргийн үржлийн аж ахуй байгуулна;
- Бүх Сумдад малын тэжээлийн үйлдвэр байгуулна.
- Аймгийн хэмжээний отрын бүс нутгийг тогтоон, зохион байгуулалттайгаар ашиглуулна.

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариалан, биотехнологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.

- Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн үет, буурцагт ургамал, жимс жимсгэнийг тариалж дотоодын хэрэгцээг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ;
- Газар тариалангийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр үйлчлэх, сэргээн засварлах, үр бордоогоор хангах лизингийн үйлчилгээ, бага механикжуулалтыг нэвтрүүлнэ;
- Газар тариаланд хөрсний эвдрэлээс хамгаалах технологи нэвтрүүлж, хөнөөлт шавьж, өвчин, хог ургамалтай тэмцэх зориулалтай бодисын хангалтыг сайжруулна;
- Услалтын системийн барилга байгууламжийг шинээр барьж байгуулах, засварлахад чиглэсэн санаачилга, хөрөнгө оруулалтыг дэмжиж, гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгийн зарим хэсгийг түүнд чиглүүлнэ;

- Үрийг нөөцлөж хадгалах, төмс хүнсний ногооны агуулах зоорийн хүчин чадал хангамжийг нэмэгдүүлэх санаачлагыг дэмжинэ;
- Айл өрхөд газар тариалан, жимс жимсгэний тарьц, суулгац үржүүлэх, туслах аж ахуйг хөгжүүлэх ажлыг бүх нийтийн хэрэгцээ болгох хөдөлгөөн өрнүүлнэ;
- Аймгийн хэмжээнд байгаа агрономич, механикжуулагч, мэргэжилтнүүдийг давтан сургахын зэрэгцээ хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд мэргэжилтэй ногоочид, тракторч-фермерийг бэлтгэнэ;
- Атаршсан талбайн судалгааг сум бүрээр гарган, ашиглах боломжтой талбайн хэмжээ, хөрсний үржил шимийн судалгаа хийнэ;
- Сэлгээнд зориулж хөх тариа, шар буурцаг, арвай, хошуу будаа, бог будаа, царгас, эрдэнэшиш, вандуй зэрэг үр тариа, тэжээлийн ургамал, үр үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ;
- Цас, борооны усыг хуримтлуулан тариалангийн усалгаанд ашиглах зорилгоор хиймэл нуур, хөв цөөрмийг байгуулна;
- Бүх суманд чацаргана болон бусад жимсний модыг тариалах, хүнсний ногоо боловсруулах цех байгуулна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Биотехнологийг тууштай нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан тарималын ургацыг нэмэгдүүлэх замаар ХАА-н салбарын үйлдвэрлэлийг жилд дунджаар 4.8 хувиар, мал аж ахуйг 4.8 хувиар, газар тариаланг 3.5 хувиар тус тус өсгөнө.

- Бэлчээрийн мал аж ахуйг хагас суурин хэлбэрт шилжүүлж, эрчимжсэн аж ахуй болгон экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ;
- Биотехнологи ашиглан малын эм, ариутгал, халдваргүйжүүлэгч бэлдмэлийн үйлдвэрлэл хөгжүүлнэ;
- Үүлдэр, омог, гойд ашиг шимт малыг богино хугацаанд өсгөх биотехнологийн аргыг өргөн нэвтрүүлнэ;
- Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ;
- Малчдын түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулна;
- Үржлийн сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгчийг сонгон бойжуулж сүү, махны чиглэлийн үхэр үржүүлгийн аж ахуйн нэгжүүдийг өргөтгөнө;
- Ноолуурын ямааны шилмэл омгийн цөм сүрэг бүрдүүлж, өсгөн үржүүлнэ;
- Тамир хонины үржлийн чанарыг сайжруулна;
- Тэрхийн бор сарлагийн загвар фермерийн аж ахуй байгуулна.

Стратегийн зорилт 2. Усалгаатай газар тариалангийн хэмжээ, 1 га-аас авах ургацыг нэмэгдүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.

- Төмс, хүнсний ногооны талбайн чийгийн ууршилтыг бууруулах, хог ургамлын ургалтыг хязгаарлах, дулаан хуримтлуулан байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах зэрэг ургац нэмэгдүүлэх арга технологийг нэвтрүүлж дэлгэрүүлнэ;
- Дулааны найдвартай эх үүсвэртэй газруудад жилийн 4 улиралд ажиллах хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ;
- Ганд тэсвэртэй, богино хугацааны болцтой, 1 га-аас авах ургацын хэмжээ ихтэй үрийн сантай болно;
- Хүнс, техник, тэжээлийн таримлын нэр төрлийг олшруулах, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуй байгуулж нарийн ногоо ургуулах ажлыг дэмжин хөгжүүлнэ.

4.2.3. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжлийн бодлого

Худалдаа, үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгож, чанар, хүртээмжийг сайжруулна.

- Бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээнд тэргүүний үйлчилгээ, өндөр технологи нэвтрүүлнэ;
- Бүсийн хүрээнд хамтран ажиллах худалдаа үйлчилгээний сүлжээ бий болгоно;
- Худалдааны төрөлжсөн төвүүдийг барьж байгуулна;
- Нийслэл, бүс нутгийн худалдааны төвүүдэд аймгийн нэрийн /ялангуяа Архангайн цагаан идээний брэнд бүтээгдэхүүний/ төв байгуулна;
- Худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийг татвар, зээл, хөрөнгө оруулалтын оновчтой бодлогоор дэмжинэ;
- Дотоод, гадаадын жуулчид, иргэдийг хүлээн авах зочид буудлыг аялал жуулчлал хөгжиж буй сумдад байгуулна;
- Худалдаа, үйлчилгээний салбарт интернет худалдаа, төлбөр тооцоог картаар хийх үйлчилгээ нэвтрүүлнэ;
- Банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, түрээс зэрэг бизнесийн үйлчилгээний салбарт цахим үйлчилгээ нэвтрүүлнэ;
- Сумдад үсчин, гоо сайхан, гэрэл зурагчин, халуун ус, саун, хими цэвэрлэгээний үйлчилгээ болон гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, компьютер, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний цэг, салбар бүхий ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулна.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын чанар, хүртээмжийг улсын жишигт ойртуулна.

- Худалдаа, үйлчилгээний салбарт өндөр бүтээмжтэй техник, технологийг тууштай нэвтрүүлнэ;
- Интернет худалдаа, цахим үйлчилгээг аймгийн иргэдийн өдөр тутмын хэрэгцээ болгоно;
- Иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн худалдаа, үйлчилгээний газруудыг хүчин чадал, үйлчилгээний нэр төрлөөр нь зохистой байршуулна.

4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого

Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл харилцаа холбооны зохистой сүлжээ бий болгон хөгжүүлнэ.

4.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого

Бүх үе шат (2011-2021 он):

Стратегийн зорилт 1. Бүсийн авто замын сүлжээ, тээврийн цаашдын хөгжлийн үндсийг тавьж, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлэх стандартын шаардлагад нийцүүлэн эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл харилцаа холбооны зохистой сүлжээ бий болгоно.

- “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн Дашинчилэн-Батцэнгэл- Завханы чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барьж ашиглалтад оруулна;
- Автозамын салбарыг хөгжүүлэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжинэ;
- Цэцэрлэг хотод автовокзал байгуулж, аймгийн Тээвэр, автозамын газрыг боловсон хүчин, санхүү-эдийн засаг, материаллаг баазын талаар бэхжүүлнэ;
- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээлээр дэмжинэ;
- Аймгийн автозамын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэн, автозамын арчлалт, хамгаалалтыг гэрээгээр гүйцэтгүүлнэ;
- Архангай–Эрдэнэтийн чиглэлийн хатуу хучилттай авто замыг барьж, ашиглалтад оруулна;
- Аймгийн нисэх буудлыг шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- Орон нутгийн замуудыг сайжруулан зарим гол дээгүүр холимог хийцийн гүүр барина;
- Цэцэрлэг хот доторхи хатуу хучилттай замыг засварлан, орон нутгийн гүүр, даваануудыг засч сайжруулах буюу шинээр барина;
- Шуудан, тээврийн үйлчилгээг нийгмийн хөгжлийг хангах чиглэлд нийцүүлэн сайжруулж, тээврийн мэдээлэл дамжуулах сүлжээ байгуулна;
- Хар Хорин-Цэцэрлэг-Солонготын давааны замыг хатуу хучилттай болгоно;
- Мянганы замтай ойролцоох сумдын төвийг хатуу хучилттай замаар холбоно;
- Төв, суурин газруудын гэрэлтүүлгийг сайжруулж, замын уулзваруудыг гэрлэн дохиотой болгоно;
- Жаргалант сумын гол төв зам болох Гурван даваа, Ноёнхангайн рашааны замыг засварлана.

4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг 2009-2015 онд жилд дунджаар 15.4 хувиар, 2016-2021 онд 11.1 хувиар өсгөн түүний аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийг 2021 онд 43.8- д хүргэн эрчим хүчний системийг зохистой өргөтгөж, эрчим хүчний хямд, найдвартай эх үүсвэрүүдийг шинээр бий болгоно.

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний салбарыг үе шаттайгаар хөгжүүлж, хямд, найдвартай эх үүсвэрүүдийг шинээр бий болгоно.

- Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэлийн төслүүдийг хэрэгжүүлж, сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн, тоног төхөөрөмжийг нь шинэчилнэ;

- Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар шийдвэрлэнэ;
- Сумдын 10/0,4 квольтын дэд өртөө, 0.4кв-ын шугамыг ээлж дараатайгаар шинэчлэн, хэрэглэгч нэмэгдсэн газруудад дэд станц нэмж суурилуулна;
- Малчин өрхүүдийг нарны эх үүсгүүрээр бүрэн хангана;
- Түлш, дулаан, эрчим хүчний алдагдлыг багасгаж, дулаан хэмнэх техник технологи нэвтрүүлэн, Аж ахуй нэгж, байгууллага, айл өрхийг урьдчилсан төлбөрт болон 3 тарифт тоолуурт шилжүүлнэ;
- Зарим бололцоотой багийн төвийг өндөр хүчдэлийн шугаманд холбоно;
- Утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулах санал санаачлагыг бүх талаар дэмжинэ;
- Бага хүчин чадалтай нам даралтын олон зуухыг өөрчлөн ашигт үйлийн коэффициент өндөртэй дулааны эх үүсвэрийг Цэцэрлэг хотын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн барьж ашиглана;
- Аймаг, сумын төвийн болон хөдөөгийн малчин өрхийг нарны гэрлийг цахилгаан эрчим хүч болгон хувиргах тоног төхөөрөмжөөр хангаж, Эмнэлэг, сургууль зэрэг төрийн байгууллагыг нарны эрчим хүчний тоног төхөөрөмжтэй болгон зардлыг бууруулна;
- Байгаль орчинд хор хөнөөлгүй, зардал хямдтай, газрын гүнд байгаа 150-270 хэмийн дулааны нөөцийг ашиглан Цэцэрлэг хотыг дулаанаар хангах геостанц байгуулна;
- Өөрийн аймгийн нутаг дэвсгэр дээр болон зэргэлдээх аймгуудын хил залгаа сумдын нутаг дэвсгэр дээрх чулуун нүүрсний ордуудыг ашиглах боломжийг судалж, шаардлага хангасан ордуудыг ашиглах бодлого явуулна;
- Аймаг, сумдын цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийг сайжруулахад чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ;
- Дулааны эрчим хүчийг үр ашигтай, хэмнэлттэй ашиглахад хот төлөвлөлт, байгуулалтын бодлогыг чиглүүлнэ;
- Цэцэрлэг хотын төвийн гудамж, гэр хороололд нар, салхи болон бусад эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан гэрэл гэгээтэй хот болгох зорилгоор “Гэрэлтүүлэг” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд хоргүй, үр ашигтай эрчим хүч, дулааны техник, технологи нэвтрүүлж, үйлдвэр үйлчилгээний үр ашгийг дээшлүүлнэ.

- Аймаг, сумдын дулааны хуучирсан шугам сүлжээг шинэчилнэ;
- Нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглана;

4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2011 – 2015 он):

Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлэлжсэн нийгэм байгуулах” үндэс суурийг тавьж, мэдээлэл холбооны орчин үеийн үйлчилгээ, хэрэглээг эрчимтэй нэвтрүүлнэ.

- Аймаг, сумдад “Цахим Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн болон төсөвт албан газар, байгууллага, төрийн албан хаагч бүрийг дотоод сүлжээ, интернетэд бүрэн холбоно;

- Электрон шууданг аймгийн хэмжээнд хөгжүүлнэ;

- Аймгийн хэмжээнд бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернет дэд хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ. Бүх сум, зарим багийн төвд интернэт төв байгуулна.

- Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, байнгын хэрэглээ болгоно;

- Аймгийн телевизийн дахин дамжуулах станцыг шинэчилж, бүх айл өрхийг кабелийн телевизтэй болгоно;

- Сумдыг өндөр хурдны шилэн кабельд холбоно;

- Сумдын төвийг телевизийн олон сувгийн нэвтрүүлэг үзэх боломжтой болгоно.

Стратегийн зорилт 2. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ, хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүхий л байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ.

- Аймгийн төвийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн сан бүрдүүлнэ;

- Аймгийн төв, зарим сумдын эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбоно;

- Электрон засаглал, арилжаа, үйлчилгээ, гарын үсэг зэрэг шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ;

- Аймгийн төв болон шилэн кабелийн гол трассын дагуу өндөр хурдны DWDM (Dense Wave Division Multiplexing) төхөөрөмж суурилуулан, сумдад шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж S-385, S-325 тавьснаар бүх сумдыг IP технологид холбогдох боломж бүрдүүлнэ;

- Суурин телефоны цэгийн нягтралыг нэмэгдүүлнэ;

- Үүрэн телефон хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж, малчдыг холбоожуулна.

Стратегийн зорилт 3. Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтний чадавхи, хэрэглэгчдийн хэрэглээний боловсролыг дээшлүүлнэ.

- Мэдээлэл, холбооны хэрэглээ, үйлчилгээг бага насны хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлэгт хүргэх сургалт явуулна;

- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн өндөр ур чадвартай мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх буюу давтан сургана.

Хоёдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Айл өрх, албан байгууллагыг шилэн кабелиар интернэтэд холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.

- Агаарын шилэн кабелийг газрын шилэн кабельд шилжүүлнэ;

- Шилэн кабельтай сумдад телевизийн сигналыг шилэн кабелиар хүлээн авдаг болгоно;

- Аймгийн төвийн гэр хорооллуудад шилэн кабелийн цагирган сүлжээ бий болгосноор айл өрх, албан байгууллагыг шилэн кабелиар интернэтэд холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3.4. Барилгын салбарын хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2011-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймаг, сумдын төвийг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлнэ.

- Цэцэрлэг хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэсэгчилсэн төлөвлөлтөөр тодотгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;
- Цэцэрлэг хотын дулаан хангамжийн нэгдсэн станц байгуулах ажлын зураг төслийг хийлгэнэ;
- Цэцэрлэг хотыг хөгжүүлэх төлөвлөлтийн хүрээнд шинээр үүсэх бичил хорооллуудын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ;
- Цэцэрлэг хотын газар доорхи инженерийн байгууламжуудын техникийн зургийг үндэслэн кадастрын зураглал хийнэ;
- Цэцэрлэг хотын гэр хорооллуудын ус түгээх цэгүүдийг төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд холбож, хот суурины хүн амын цэвэр усны хангамжийг сайжруулна;
- Цэцэрлэг хотын төв талбайг тохижуулж, усан оргилуур бүхий хүүхэд, залуучуудын цэнгэлдэх хүрээлэн байгуулна;
- Цэцэрлэг хот, төв суурин газрын барилга байгууламжуудын газар хөдлөлтийн нөхцөлийн бат бэх байдлын судалгаа хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Онгоцны буудлын талбайн 60 га газарт орон сууцны жишиг иж бүрэн хорооллыг байгуулна;
- Томоохон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг бүс нутгийн хөгжлийн төлөв байдалтай уялдуулна;
- Аймгийн төв болон сум, томоохон суурингуудыг төвлөрсөн дулаан болон цэвэр усан хангамж, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ;
- Инженерийн байгууламжуудын хүчин чадлыг тооцож, барилга байгууламжид техникийн нөхцөл олгох боломжуудыг бүрдүүлнэ;
- Аймгийн хэмжээнд барилга, байгууламжуудын насжилтыг тодорхойлно;
- Багийн төв, сумдын Засаг даргын Тамгын газрын конторын барилгыг засварлах буюу шинээр барих ажлыг ээлж дараатайгаар шийдвэрлэнэ.
- Сумдын эхчүүдийн амрах байруудыг өргөтгөн засварлах, шаардлагатай сумдад амбулаторын байрыг шинээр барина;
- Эрдэнэбулган сумын гэр хороололд сургууль-цэцэрлэгийн цогцолбор байгуулна;
- Эрдэнэбулган сумын үерийн хамгаалалтын далан шинээр барих, ус зайлуулах шуудууг сэргээнэ;

Стратегийн зорилт 2. Орон нутгийн түүхий эд, байгалийн баялагт тулгуурласан барилгын материалын үйлдвэрүүдийг хөгжүүлнэ.

- Орон нутгийн барилгын материалын ордуудаас технологийн сорьц авч лабораторийн шинжилгээнд хамруулснаар барилгын материалын чанар, стандартыг тодорхойлно;

Стратеги зорилт 3. Хот суурингийн газар ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

- Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх, газрыг иргэн бүрт үнэгүй өмчлүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулна;

- Газрын мэдээллийн системийг бий болгон олон нийтэд шуурхай үйлчилдэг болгоно;

- Газрын мониторингийн сүлжээ бий болгож, доройтолд орж, эвдэрч талхлагдсан газрыг нөхөн сэргээж сайжруулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ;

- Үл хөдлөх эд хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулж, өмчийн бүртгэлийн системийг боловсронгуй болгон бэхжүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

- Аймгийн төв, төвлөрсөн суурингуудад орон нутгийн хямд чанартай материалыг ашиглан иргэд, оршин суугчид ая тухтай, ажиллаж амьдрах орчин, нөхцөл бүрдүүлсэн тохилог орон сууц барих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;

- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл хэрэгжүүлнэ;

- Орлого багатай буюу нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийг орон сууц, байраар хангах арга хэмжээ авна;

- Орон сууц барихад хувийн секторийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ;

- Бохир усны цэвэрлэх байгууламж байгуулж, цэвэрлэсэн усыг дахин ашиглана.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

Экологийн аюулгүй байдлыг хангах, тэр дундаа хүрээлэн байгаа орчныг хамгаалах, баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогын хэрэгжилтийг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг бууруулах ажлыг эрчимтэй хэрэгжүүлэхийн зэрэгцээ аялал жуулчлалын салбарыг нийгэм эдийн засгийн хөгжлийг тогтвортойгоор өсгөн нэмэгдүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэгч, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ.

Бүх үе шат (2011-2021 он):

Стратегийн зорилт 1. Байгаль орчны доройтлыг сааруулна.

- Аймаг, сумдын байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ;
 - Байгаль орчинд учирсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ;
 - Сэргээгдэх эрчим хүч ашиглалтыг нэмэгдүүлнэ;
 - Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, цэцэрлэгжүүлэн, зүлэгжүүлнэ;
 - Цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад мод бут сөөг тарьж, ойн зурвас байгуулна;
 - Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, байгальд халгүй аргаар устгах технологи, менежментийг нэвтрүүлнэ;
-
- Байгаль хамгаалахад иргэд, нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлнэ.
 - Хайгуул, ашиглалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэнэ;
 - Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг бууруулах ажлыг эрчимжүүлнэ;
 - Хөрс хамгаалах арга хэмжээг шинжлэх уханы үндэстэй зохион байгуулна.

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

- Газрын нөөцийн менежментийг сайжруулж, газар зохион байгуулалтын албыг орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана;
- Байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, нэн ховор ан амьтан, ургамлын тархацтай нутаг, аялал жуулчлал хөгжсөн бүс нутгийг аймгийн тусгай хамгаалалтад авна;
- Инженерийн хийцтэй уст цэгийг засварлах буюу шинээр гаргах замаар бэлчээрийн усжуулалтын түвшинг дээшлүүлнэ;
- Тариалангийн талбайг тойруулан ойн зурвас байгуулж, тэжээлийн болон эмийн ургамал тариална.

Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

- Төв, суурингийн цэвэр усны бохирдлыг бууруулна;
- Гадаргын болон гүний усны тооллого, бүртгэлийг нарийвчлан гаргаж, мэдээллийн сантай болно;
- Орхон голын урсацыг сайжруулах замаар Өгийнуурын усны түвшинг нэмэгдүүлнэ;
- Сумдад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хангамжийг нэмэгдүүлэх;
- Экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглана;
- Хурын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулан усны нөөцийг хамгаална;

- Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, рашааны эхийг тохижуулан хамгаална;
- Усны хими, физик, биологийн судалгаа явуулж, геохими, гидрохимийн зураг зохиож, усны нөөц, чанарын үнэлгээ өгөх шалгуурыг тогтооно;
- Төв, суурин газрын ундны усны эх үүсвэрийг иоджуулан цэнгэгжүүлж, эрдэсжилтийг багасгана;
- Төв суурин газрын агаар, хөрс, усны бохирдолттой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх замаар иргэдийн эрүүл мэндийг хамгаална.

Стратегийн зорилт 4. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулж экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийх, нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ;
- Ой хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх хүний нөөцийг бэлтгэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана;
- Мод тарих, цэцэрлэгжүүлэх, голын усны эхийг хамгаалах, ойн зурвас байгуулах ажилд олон нийтийг хамруулан, сургалт зохион байгуулж, тэдгээрийг урамшуулах механизмыг бий болгоно,;
- Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах мэргэжлийн хүмүүс бэлтгэж, багаж, тоног төхөөрөмжөөр ханган, ойн түймрээс хамгаалах зурвасыг технологийн дагуу байгуулна;
- Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх бактерийн бэлдмэлийн цех байгуулна;
- Ойн дагалдах баялгийг ашиглах, ойн химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ;
- "Ногоон хэрэм" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;
- Ойн нөөц ашиглалтын төлбөрийн 70 хүртэл хувийг ой хамгаалах арга хэмжээнд зориулах эрх зүйн орчин бүрдүүлнэ;
- Архангай МСҮТ-ийг түшиглэн ойн аж ахуй байгуулах, сум бүрт мод сөөгний үр бэлтгэх хүлэмж, мод үржүүлгийн газар байгуулна;
- Айл өрх, албан байгууллагын түлшинд ургаа залуу мод хэрэглэхийг зогсооно.
- Айл өрхийн нүүрсний хэрэглээг багасгаж, утаагүй түлшний хэрэглээнд шилжүүлнэ;
- Ойн хаягдлыг зохистой ашиглана.

Стратегийн зорилт 5. Ургамал, амьтны аймгийн нөөцийг тогтоож, байгалийн жамаар нөхөн сэргээх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

- Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө;
- Аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;
- Ховор, нэн ховор амьтан, ургамлыг сэргээн нутагшуулна;
- Агнуурын эдэлбэр нутагт ан амьтдад зориулан өвс тэжээл бэлтгэх, биотехнологийн аргыг өргөн нэвтрүүлнэ;
- Агнуурын үндсэн хөхтөн амьтдын тооллого хийж, тархалтыг нь тогтоон, нуур, гол мөрний загасны нөөцийг судална.

Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилтийг сааруулах чадавхийг бүрдүүлнэ.

- Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төв байгуулна;
- Мэргэжлийн хяналтын лабораториудыг орчин үеийн техник хэрэгслээр хангаж, хүний нөөц бэлтгэнэ;
- Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенци, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана;
- Ган, цөлжилтийн явц, орчны өөрчлөлтийн хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлнэ;
- Цаг уурын хэмжилтийн цэгийн нягтрал, тэдгээрийн хэмжилтийн тоо, хэмжих элементүүдийг нэмэгдүүлж, чичирхийллийн станцад техникийн шинэчлэл хийнэ.

Стратегийн зорилт 7. Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн биеэ даасан тэргүүлэх салбарын нэг болгоно.

- Архангай аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”/2010-2021/-г хэрэгжүүлнэ;
- Олон улсын стандартад нийцсэн аялал жуулчлалын дэд бүтэц хөгжүүлнэ;
- Цэцэрлэг хотод аялал жуулчлалын цогцолбор байгуулж ажиллуулна;
- Дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчны бааз, түр буудаллах дэн буудлын сүлжээ байгуулна;
- Аялалын тогтоосон маршрутын дагуух гүүр, авто замыг засварлан, тэмдэгжүүлнэ;
- Түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг бүртгэлжүүлж, аялал жуулчлал, үзмэрийн зориулалтын нөхцөл бүрдүүлнэ.
- Түүх, соёлын дурсгалт газруудын унаган төрхийг хадгалах, нөхөн сэргээх арга хэмжээ авна;
- Өвлийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Аялал жуулчлалын баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн стандартыг хангасан жуулчны бааз, эко гэр байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ;
- Байгаль орчны шинжилгээний лабораторийг орчин үеийн техник технологээр шинэчлэн, шинжилгээ судалгааны ажлын хүрээг өргөжүүлнэ.

ЗУРГАА. НУТГИЙН УДИРДЛАГА, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО, ТҮНШЛЭЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО

Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэн төрийн үйлчилгээний өндөр соёл, хүртээмж, сэтгэл ханамжийг төлөвшүүлснээр хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална.

Бүх үе шат (2011-2021 он):

Стратегийн зорилт 1. Нутгийн хурал, захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлж ил тод байдлыг хангана.

- Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, төрийн байгууллагад хяналт тавих, нөлөө үзүүлэх, дэмжлэг авах чиглэлээр төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын түншлэлийг өргөжүүлнэ;
- Орон нутагт нээлттэй, ил тод, өрсөлдөөнт тендерээр ажил гүйцэтгэх явдлыг идэвхжүүлж, энэ чиглэлээр арга, туршлагаа солилцох явдлыг дэмжинэ;
- Нутгийн хурал, захиргааны байгууллагууд шийдвэр гаргахын өмнө иргэдийн санал, бодлыг судалж, шийдвэрт тусгах бодлого барьж ажиллана;
- “Орон нутгийн хөгжилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ;
- Төрийн байгууллагуудын албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулна;
- Аймаг, сумдын гамшгийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ хийнэ;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор бүх сумдыг холбооны техник хэрэгслээр хангана;
- Ард иргэдэд, гамшгаас хамгаалах мэдлэг, боловсрол олгоно;
- Аймаг, сумдад гамшгийн үед ашиглах эрсдлийн сан бүрдүүлнэ;
- Онцгой байдлын хэлтсийн аврах, гал унтраах автомашин, техник хэрэгслийг шинэчилнэ;
- Ард иргэд, аж ахуйн нэгжийг гамшгийн даатгалд хамруулах боломж бүрдүүлнэ;
- Газар хөдлөлт, ой, хээрийн түймэр, үер, ган, зуд, хүн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын аймгийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ;

Стратегийн зорилт 2. Төрийн үйлчилгээг иргэдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны хамгийн анхан шатны нэгжийн хувьд багуудыг бэхжүүлэн хөгжүүлнэ. Багийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Төрийн бүртгэлийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэний баримт бичгийг цахимжуулна;
- Төрийн албаны төлөвлөлтийг сайжруулснаар үр дүнд чиглэсэн удирдах, манлайлах чадавхийг бэхжүүлнэ;
- Шийдвэр нь ил тод байх, ажлын үр дүнд чиглэсэн суралцагч байгууллагыг хөгжүүлнэ;
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх нийгмийн аудитыг нэвтрүүлнэ;
- Байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хянах нээлттэй, цахим системтэй болно;
- Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхи бүрдүүлэн, үр нөлөөг нь дээшлүүлнэ;
- Багийн засаг дарга нарыг унаажуулна;

- Аливаа төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд эн түүнд баримт бичиг, биеийн байцаалт үнэн зөв байх шаардлагыг харгалзан “нэг иргэн-нэг бүртгэл” зорилтыг хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт 3. Иргэдийн ая тухтай амьдрах орчин, нөхцөлийг хангаж, түүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

- Иргэдийн амгалан тайван, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөл бүрдүүлж гэмт хэрэг, зөрчлийг бууруулна;

- Хууль хяналтын байгууллагуудын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулахад чиглэгдсэн орчин үеийн ажлын арга хэлбэр, механизмыг нэвтрүүлнэ;

- Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах бодлого баримтлан аймгийн байгууллага, аж ахуйн нэгж, хүн амыг болзошгүй гамшиг, ослоос сэргийлэх, хамгаалах чадамжийг дээшлүүлнэ.

Стратегийн зорилт 4. Аймгийн гадаад харилцаа, түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлнэ.

Гадаад харилцааг эдийн засагжуулах бодлогын хүрээнд дараахь чиглэлээр харилцан үр ашигтай гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Үүнд:

- Хөрш хоёр орны уламжлалт харилцаат муж болон бусад улс орны мужуудтай харилцан ашигтай гадаад харилцааг идэвхижүүлж, бүс нутаг, олон улсын байгууллагуудын болон худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаанд оролцох;

- Мал аж ахуй, газар тариалангийн гаралтай болон бусад бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

- Аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх босоо тэнхлэгийн авто зам барих;

- Үр тариа, тэжээлийн олон наст ургамлын үр, таримал ургамлын үр болон үржлийн мал бэлтгэх, дагнасан болон хамтарсан фермерийн аж ахуй байгуулах;

- Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн зориулалттай машин, техник, хэрэгсэл импортлох;

- Ашигт малтмалын зарим орд газруудыг хамтран ашиглах;

- Услалтын систем байгуулах, мод, жимс, жимсгэнэ, малын тэжээл, төмс, хүнсний ногооны талбайг өргөжүүлэх ;

- Соёл, боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэгийн болон хүүхдийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

- Аймагт хэрэгжиж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоо, үр дүнг сайжруулах;

- Бусад аймаг, нийслэлд байгуулагдах үйлдвэрлэл, технологийн болон шинжлэх ухаан, технологийн паркуудтай нягт хамтран ажиллах, уг паркуудын зарим салбаруудыг Архангайд байгуулах;

- ОХУ, БНХАУ руу хамгийн дөт замаар гарах хилийн гарцтай болгох нөхцөлийг бүрдүүлэх;

- Архангай нутгийг хөгжүүлэхийн төлөө сэтгэл, зүтгэлтэй бусад аймаг, нийслэл, гадаад, дотоодод ажиллаж, амьдарч байгаа бүх иргэд, ажил хэрэгч хүмүүс, эрдэмтэд, түншүүдтэй нягт хамтран ажиллах;
- Хангайн бүсийн бүх аймгуудтайгаа эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

7.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

Архангай аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлснээр дараахь томоохон үр дүнд хүрнэ.

7.1.1. Нийгмийн хөгжлийн хүрээнд I үе шат (2011-2015 он)-нд:

Ядуурлын түвшин тогтвортой буурч, ажилгүйдлийн хувьд хамгийн бага байгаа эхний таван аймгийн түвшинд хүрч, нийгмийн баялгийг бүтээхэд иргэдийн оролцоо нэмэгдсэн байна. .

Өрхийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжих аймгийн тусгай хөтөлбөр хэрэгжиж үр дүнгээ өгнө.

1000 хүн амд ногдох төрөлт, нас баралт болон хүн амын дундаж наслалт улсын дундаж түвшинд хүрсэн байна.

Малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй залуус нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдсан байна.

Явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэгүүд бүх сум, багуудад ажиллана.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүд ажиллана.

Боловсролын бүх шатны байгууллагуудын материаллаг бааз бэхжиж, удирдлагын менежмент нь сайжирсан байна.

Нэг эмчид ногдох хүний тоо Хангайн бүсийн дунджид, нялхсын эндэгдэл улсын дундаж түвшинд хүрсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, хүний нөөцийн хангамж сайжирсан байна.

II үе шат (2016-2021 он)-нд:

Хүн амын жилийн дундаж өсөлт болон хүний хөгжлийн индекс улсын дундаж түвшинд хүрсэн байна.

Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинж олон улсын нийтлэг жишигт хүрсэн байна.

Соёл урлагийн байгууллагууд биеэ даан хөгжих оновчтой тогтолцоо бүрдэж, үйлчилгээний хүртээмж, чанар нь сайжирсан байна.

Эрүүл мэндийн салбарын удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоо бүрдсэн байна.

Өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх орчин үеийн дэвшилтэт арга ажиллагаа нэвтэрч, хүн амын эрүүл мэнд сайжирч, дундаж наслалт нэмэгдсэн байна.

7.1.2. Эдийн засгийн хөгжлийн хүрээнд I үе шат (2011-2015 он)-нд

Бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирч, эрдэс баялгийн үйлдвэрүүд байгуулагдана.

Аймгийн ДНБ-ий хэмжээ 2009-2015 онд жилд дунджаар 5.8 хувийн өсөлттэй байх ба 2015 онд 2005 оны үнээр тооцвол 97809.61 мянган төгрөгийн бараа, үйлчилгээ үйлдвэрлэх боломжтой болно.

Харин нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2015 онд 1119.4 мянган төгрөг болж 2009 онтой харицуулахад 1.6 дахин өснө.

Нэгдүгээр үе шатанд аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2009 онд 0.7 байсан бол 2015 онд 1.4-д хүрч 2 дахин нэмэгдэнэ. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт энэ үе шатанд 19.2 хувьтай байна.

Боловсруулах салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 24.3 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 51.2 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийн эхлэл тавигдана.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 15.4 хувиар өсч, уг салбарын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2015 онд 50.2-д хүрнэ.

Барилгын салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 3.5 хувиар тогтмол өсөх нөхцөл бүрдэнэ.

Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлснээр малын үүлдэрлэг чанар сайжирч, ХАА-н салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 6.7 хувиар өсч, ХАА-н салбарын үйлдвэрлэлийн аймгийн ДНБ-д эзлэх хувь 2015 онд 76.7 болно. Мөн энэ үе шатанд салбарын жилийн дундаж өсөлт газар тариаланд 4.5, МАА-д 6.8 хувьд тус тус хүрнэ.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 6.9 хувиар өснө. Уг салбарын ДНБ-д эзлэх хувь 21.3 болж салбарын бүтцэд бага зэрэг өөрчлөлт гарна.

II үе шат (2016-2021 он)-нд

Аймгийн эдийн засгийн бүтэц сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдэрнэ.

Аймгийн ДНБ-ий хэмжээ энэ үед жилд дунджаар 4.9 хувийн өсөлттэй байх ба 2021 онд 2005 оны үнээр тооцвол 130314.37 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг үйлдвэрлэх боломжтой бол 2015 онтой харьцуулбал, ДНБ-ий хэмжээ 1.3 дахин нэмэгдэнэ.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2021 онд 1568.9 мянган төгрөгт хүрч, 2015 оныхоос 1.4 дахин өснө. Тус аймгийн нэг хүнд 2021 онд 1307.4 ам долларын бараа, үйлчилгээ ногдох болно. Тооцооны үр дүнгээс үзэхэд 2021 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онтой харьцуулахад 2.17 дахин нэмэгдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт энэ үе шатанд 13.7 хувьтай байх ба ДНБ-д эзлэх хувийн жин 2021 онд 2.3 хувьд хүрнэ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 15.9 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 57.5 хувийг үйлдвэрлэнэ.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 11.1 хувиар өсч, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь 2021 онд 43.8- д хүрнэ.

Барилгын салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 2.8 хувиар өснө.

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл энэ үе шатанд жилд дунджаар 4.8 хувиар өсч, 2021 онд тус салбарын ДНБ-д эзлэх хувь 76.1 болно.

7.1.3. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хүрээнд Бүх үе шат (2016-2021 он)-нд

Байгаль орчны доройтол саарч, газар ашиглалтын оновчтой тогтолцоо бүрдэнэ.

Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөл үе шаттайгаар бүрдэнэ.

Аялал жуулчлалын салбар эдийн засгийн биеэ даасан тэргүүлэх салбарын нэг болно.

7.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм

Архангай аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрүүд болон Засаг даргын мөрийн хөтөлбөр, энэ баримт бичгийн хүрээнд боловсруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ.

Цогц бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг аймгийн Засаг даргын тамгын газраас нарийвчлан боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг Засаг дарга дараа жилийн эхний улиралд багтаан Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаварыг үнэлэн дүгнэх ажлыг дараахи үе шатуудаар зохион байгуулна. Үүнд:

I үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2015 оны эхний хагаст);

II үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2021 оны эхний хагаст).

Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын Газар холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр тогтмол хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

_____о О о_____